



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Сан байгуулах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Шүүхийн “Ахмадын сан” байгуулсугай.
2. “Ахмадын сангийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
3. Ахмадын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд төлөвлөн тусгаж байхыг Ажлын алба /О.Амгаланбаатар/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЛҮНДЭНДОРЖ

000315

ШҮҮХИЙН АХМАДЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шүүхийн Ахмадын сан (цаашид "сан" гэнэ)-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Шүүхийн тухай багц хууль, Төсвийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Ахмадын сан байгуулан ажиллуулах журам, бусад хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.
- 1.3. Сан өөрийн данстай байна.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

- 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:
 - 2.1.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөнөөс давсан орлогын 10 хүртэл хувь болон цалингийн нийт сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 2.1.2. Сангийн үйл ажиллагаанаас олох орлого;
 - 2.1.3. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;
 - 2.1.4. Гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;
 - 2.1.5. Сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого;
 - 2.1.6. Бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

- 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6-д заасан дараах арга хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулна:
 - 3.1.1. Шүүхийн байгууллагад онцгой үр бүтээл гарган олон жил идэвхи зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэмж олгох;
 - 3.1.2. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах;
 - 3.1.3. Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.4. Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.5. Шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.6. Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх;

- 3.1.7. Ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;
- 3.1.8. Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 3.1.9. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангүй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж олгох;
- 3.2. Энэхүү журмын 3.1.2, 3.1.8-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20 хувиас багагүй байхаар тогтоож, байгууллагын төсөв болон дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
- 3.3. Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно.
- 3.4. Сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт болон бусад шаардлагатай холбогдох баримт бичгийг бүрдүүлэн харьяа Ахмадын салбар зөвлөлөөрөө уламжлуулан Шүүхийн ахмадуудын холбоонд хүсэлт гаргана.
- 3.5. Шүүхийн ахмадуудын холбооны албан ёсны саналыг үндэслэн хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 3.6. Шүүхийн ерөнхий зөвлөл өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд сангийн хөрөнгийг ахмадуудын бүртгэлийн хамт тухайн байгууллагын эрх, үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдэд шилжүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

- 4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад аудит холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 4.2. Ахмад настанд нэмэгдэл тэтгэмж, тусламж, дэмжлэг олгох, сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба болон Шүүхийн Ахмадуудын холбоо хамтран хариуцан гүйцэтгэнэ.
- 4.3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Шүүхийн Ахмадуудын холбоонд ирүүлнэ.